

БАТЛАВ

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

Г.ЭНХМӨНХ

БАТЛАВ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Х.МӨНХЖАРГАЛ



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТАВАНТОЛГОЙ
НҮҮРСНИЙ ОРДЫН ЦАНХИЙН УУРХАЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:
MV- 016881, MV- 016882, MV- 011943, MV- 016883

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5435528

ХЯНАСАН:

УУЛ УУРХАЙН НӨЛӨӨЛЛИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ ШИНЖЭЭЧ

Ц.ЖАРГАЛНЭМЭХ

БОЛОВСРУУЛСАН:

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА

Б.БАТСАЙХАН

Гарчиг

1	Төслийн танилцуулга	1
1.1	Оршил	1
1.2	Үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал.....	1
1.3	Тавантолгой ордын геологийн тогтоц.....	2
1.4	Уулын ажлын ерөнхий мэдээлэл.....	2
1.5	2025 оны уулын ажлын төлөвлөлт	2
1.6	Туслан гүйцэтгэгч байгууллагуудын мэдээлэл	2
2	Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	3
2.1	Уур амьсгал	3
2.2	Геоморфологи	3
2.3	Ус зүй ба гидрогеологийн нөхцөл	4
2.4	Хөрс.....	4
2.5	Ургамлан бүрхэвч.....	4
2.6	Нийгэм, эдийн засаг	4
3	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	5
3.1	Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц.....	5
3.2	Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээ	7
4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	11
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	12
5.1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
5.2	Гадаргын ба газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
5.3	Хөрсөн бүрхэвчид нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
5.4	Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
5.5	Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
5.6	Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	20
7	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ.....	22
7.1	Биологийн олон янз байдал талаар баримтлах бодлого	22
7.2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	23
8	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	25
9	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	26
10	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	27
11	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	30
12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	32
12.1	Агаарын чанарын хяналт шинжилгээ	32
12.2	Усны хяналт шинжилгээ	34
12.3	Хөрс, ургамлан бүрхэвчийн мониторинг	35
13.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	37
14	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	39

15	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв.....	40
----	---	----

1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Оршил

Уул уурхай үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг зөв оновчтой тодорхойлж түүнийг арилгах, багасгах, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх нь хариуцлагатай уул уурхайн үндсэн зарчмуудын нэг юм.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь улс орон болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулахын зэрэгцээ нээлттэй ил тод байдал, тогтвортой хөгжлийг үнэт зүйлээрээ тодорхойлсон. Тиймээс байгаль орчны хамгааллын асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч ажиллаж байна.


Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон хүчин төгөлдөр хэрэгжиж буй Монгол Улсын холбогдох хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн 2021-2025 оны стратеги төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан болно.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь олон улсын нэгдсэн менежментийн тогтолцоог /ISO 14001:2015, ISO 45001:2018, ISO 9001:2015/ нэвтрүүлснээр байгаль орчны асуудлуудыг албан ёсоор тодорхойлж тэдгээрийг шийдвэрлэх шат дараатай алхмуудыг бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж байна. Стандартын хүрээнд тоосжилт бууруулах, үйлдвэрт ашиглах гадаргын усны хэмжээг нэмэгдүүлэх газар доорх усны хэрэглээг багасгах, биологийн задралд ордог бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх, хог хаягдлын дахин боловсруулалтыг сайжруулах замаар байгальд хаях хог хаягдлын хэмжээг бууруулах, хүрээлэн буй орчинд учруулж байгаа сөрөг нөлөөллийг ялангуяа агаар бохирдуулагчийг хянах тогтолцоог олон улсын түвшинд хүргэх, олон талын хэлэлцүүлэгт үндэслэсэн хаалтын бодлогыг бий болгох, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зэрэг гол асуудлуудыг байгаль орчны гол шалгууруудаар тодорхойлсон.

Дээрх стандарт шаардлага, төлөвлөлт, хариуцлагын хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх ажлыг энэхүү төлөвлөгөөнд тусгасан ба Тавантолгой ордын Цанхийн баруун болон зүүн уурхайн төслийн гэрээт гүйцэтгэгч компаниудад нэгэн адил хэрэгжүүлнэ.

1.2 Үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал

Тавантолгой нүүрсний орд газар нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг Улаан нуурын хөндийд, Улаанбаатар хотоос өмнө зүгт 540 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгад сумаас зүүн урд зүгт 90 км, Цогтцэций сумын төвөөс баруун өмнө зүгт 18 км, Сайншанд өртөөнөөс 440 км, Монгол-Хятадын хилийн Гашуун Сухайт боомтоос 240 гаруй км, Оюутолгой зэс, алтны ордоос 150 гаруй км-ийн зайд оршдог.



Зураг № 1. Тавантолгой ордын байршил.

1.3 Тавантолгой ордын геологийн тогтоц

Орд нь Өмнөд говийн нүүрсний сав газарт багтдаг Улаан нуурын нүүрст хөндийн (200 ам км) баруун хэсгийн Тавантолгой синклиналь атриа (100 ам км)-нд хамаардаг.

Тавантолгой синклиналь атирааны төв хэсэг дээд пермийн нүүрс агуулагч хурдсаар дүүргэгдэж дунд-дээд девон, доод карбон, хожуу карбон-түрүү пермийн вулканоген тунамал хурдсууд ордыг эмжээрлэн тогтох гүвээ толгод илэрнэ. Хязгаарлагдмал бага талбайд кайнозойн хурдас хөгжсөн байдаг.

Тавантолгой ордын Тавантолгой формацын нүүрс агуулагч хурдаст 1-86 метр хүртэл зузаантай нүүрсний 0-XIII нэршилтэй (VIII давхраас чулууны үетэйгээр 1298-р цооногт 86.2м, 1295-р цооногт 74 метр зузаантай тэмдэглэгдсэн байдаг) давхраасууд агуулагддаг байна. Цанхийн талбайн хэмжээнд нүүрсний 0-IX хүртэлх 10 давхраас байдаг ба талбай нь баруун талаараа хайгуулын XII, зүүн талаараа XIII, хойд талаараа XI шугамаар хязгаарлагддаг ажээ. Дээд пермийн нүүрс агуулагч хурдсанд агуулагдах нүүрсний давхраасууд нь янз бүрийн чиглэлд хэд хэдэн удаагийн давтамжтайгаар салаалан зузаан нь багасч яваандаа шувтарч алга болдог байна.

Нарийвчилсан болон ашиглалтын хайгуулын явцад тогтоогдсон томоохон хагарлын ойр орчинд тасралтат эвдрэлийн шинж тэмдгийг илэрхийлсэн хэдэн нэмэлт атираажилт тогтоогдсон байдаг байна. Нарийвчилсан, урьдчилсан хайгуулын талбайд явуулсан өрөмдлөгийн материал, хайгуулын зүсэлтүүдийг боловсруулан үзэхэд ордын хэмжээнд нүүрсний үндсэн давхраасууд нь харьцангуй тогтвортой нь ажиглагдаж байсан. Нүүрсний давхрааст ихэвчлэн нүүрслэг аргиллит, алевролит, элсэн чулуу, каолинитын үеүд илэрдэг. Тавантолгой формацын давхаргазүйн зүсэлтийн доод хэсэгт багаас дунд зэргийн зузаантай давхраас (0, I, II, III, IV), дунд хэсэгт их зузаантай давхраас (VIII-IX), дээд хэсэгт бага-дунд зэргийн зузаантай давхраас (X-XIII) тус тус тохиолддог байна.

1.4 Уулын ажлын ерөнхий мэдээлэл

2024 онд Цанхийн баруун уурхайд 63.1 сая.м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, 12.1 сая тонн нүүрс олборлож, нийт 71.8 сая.м3 уулын цул хөдөлгөж 11.5 сая тонн нүүрсийг экспортонд гаргасан байна. Цанхийн зүүн уурхайд 70.6 сая.м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, 18.4 сая тонн нүүрс олборлож, нийт 83.7 сая.м3 уулын цул хөдөлгөж 18.4 сая тонн нүүрсийг экспортонд гаргасан байна.

Уурхайн үйл ажиллагаа 2010-2024.12.31-ний байдлаар Цанхийн уурхайгаас нийтдээ 153.97 сая тонн нүүрс олборлон 652.8 сая м3 хөрс хуулж, 762.4 сая м3 уулын цулын ажил гүйцэтгэн 148.2 сая тонн нүүрсийг экспортонд гаргасан байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Тавантолгой ордод үйл ажиллагаа явуулж буй уурхай тэдгээрийг дагасан төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулж Тавантолгой ордыг цогц, иж бүрнээр ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахаар төлөвлөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу 2024 онд нээлттэй сонгон шалгаруулалт явуулан “Роял майнинг”, “Эм Эм Маркет” ХХК-иудын хамтарсан түншлэлтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

1.5 2025 оны уулын ажлын төлөвлөлт

2025 онд Цанхийн зүүн уурхайд 85.2 сая.м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэж 15.0 сая тонн нүүрс олборлож, нийт 95.9 сая.м3 уулын цулын ажил, Цанхийн баруун уурхайд 95.3 сая м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, 15.0 сая тонн нүүрс олборлож, нийт 106.1 сая м3 уулын цулын ажил тус тус гүйцэтгэхээр төлөвлөсөн.

1.6 Гэрээт гүйцэтгэгч байгууллагуудын мэдээлэл

Хүснэгт 1. Гэрээт гүйцэтгэгч компаниудын мэдээлэл.

Байгууллагын нэр	Хамтран ажиллах чиглэл	Байгууллагын хаяг
“Ти Эн Түншлэл”	Хөрс хуулалт хүүрс олборлотын ажил гүйцэтгэх	ХУД, 15-р хороо, Моннис Бьюлдинг 6-р давхар
“Кэй Эй Майнинг” ХХК	Хөрс хуулалт хүүрс олборлотын ажил гүйцэтгэх	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Жамъян гүний гудамж, Ай Си Си тауэр 7 давхар 701 тоот

“Үндэсний Оператор Түншлэл”	Хөрс хуулалт хүүрс олборлотын ажил гүйцэтгэх	Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг Чингисийн өргөн чөлөө Нью Сенчурн Плаза
“Үндэсний Манлайлал Түншлэл”	Хөрс хуулалт хүүрс олборлотын ажил гүйцэтгэх	Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 19-р хороолол, Мөнх тауэр, 701 тоот.
“Үндэсний Уурхайчин Түншлэл”	Хөрс хуулалт хүүрс олборлотын ажил гүйцэтгэх	Өмнөговь аймаг Цогтцэций сум, Цагаан овоо баг, Таван толгойн уурхай дахь Кэй Эй Майнинг ХХК-ийн оффис
“Овоот Толгой Ресурсес” ХХК	Хөрс хуулалт хүүрс олборлотын ажил гүйцэтгэх	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-13, Ланд Марк оффис, 201 тоот
“Спейшл Майнинг Сервис” ХХК	Өрөмдлөг, тэсэлгээний ажил гүйцэтгэх	БЗД, 25-р хороо, Жамъян гүний гудамж 18/1 Даун Таун оффис, 6 давхар, 602 тоот
“Кэй Эй Рентал Сервис” ХХК	Нүүрс ачилтын ажил гүйцэтгэх	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Жамъян гүний гудамж, Ай Си Си тауэр 7 давхар 701 тоот
“Ти Ти Жи Ви Си Өү” ХХК	Нүүрс ачилтын ажил гүйцэтгэх	Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Их Монгол Улсын гудамж, Моннис цамхагийн 6-р давхар

2 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Уур амьсгал

Цогтцэций сумын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -14.8°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 41.3°C хүрдэг байна. Хөрсний гадаргын дундаж температур нь ойролцоогоор 8.0°C байдаг.

Жилийн дундаж агаарын температур нь 0.9°C , хамгийн хүйтэн сар болох I сарын дундаж температур -14.6°C бол хамгийн дулаан сар болох VII сарын дундаж температур 23.1°C байдаг байна.

Цогтцэций суманд жилд дунджаар 76.7 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 52.7 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 68 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна.

Салхины зонхлох чиглэлийн хувьд манай ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд баруун хойноос нийт салхины чиглэлийн 38.8%, баруунаас 20.7%, баруунаас 9.4% давтагдалтай байдаг.

Салхины хурдны олон жилийн дундаж нь ойролцоогоор 5.1 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул салхины хурд багасдаг боловч зарим жил 34 м/с хүрч шороон болон цасан шуурга шуурч байсан тохиолдол цөөнгүй.

2.2 Геоморфологи

Гадаргуугийн хувьд ерөнхийдөө нам уулс, жижиг толгод, талархаг гадаргуу зонхилох ба далайн түвшнээс дээш 1490-1590 м өргөгдсөн. Хамгийн өндөрлөг цэгүүд нь Тавантолгой талбайгаас баруун урагш орших Бага уул /1731.1 м/, зүүн хойно байх Майга улаан уул /1587.5 м/, чанх урагш орших Нэргүй өндөрлөг /1652.2 м/, зүүн урагш байх Тавантолгой уул /1570 м/ зэрэг болно. Хамгийн нам цэгүүдэд Улаан нуур болон бусад нуур тойрмуудын хөндий орно. Голын хөндийнүүд нь ерөнхийдөө өргөрөгийн чиглэлтэй ба элсэрхэг, шаварлаг хурдсаар дүүргэгдсэн байдаг. Физик газар зүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газар зүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтана.

Гадаргуу нь гарал үүслийн шинж чанараа денудацийн буюу зөөгдлийн, структур-денудацийн, эрози-денудацийн буюу элэгдэл-зөөгдлийн, денудаци-хуримтлалын бүрдэлд хуваагддаг.

2.3 Ус зүй ба гидрогеологийн нөхцөл

Талбайн хэмжээнд байнгын урсгал ус байхгүй. Бороо их орсон үед хуурай сайр жалга нь түр зуурын урсгал устай болох ба уулс хоорондын хөндий, хотгоруудад түр зуурын давсархаг нуурууд үүсдэг. Уурхайн үерийн шуудуу, хөрсний овоолго, дэвсэлт хийж байгуулсан зам зэрэг антропоген байгууламжуудад хаагдан түр зуурын тогтонги ус үүсч бий болдог ба тус усыг уурхайн тоосыг бууруулахад өргөн хэрэглэж байна. Колдышева. Р.Я. нарын зохиосон гидрогеологийн 1:500000 зурагт Улаан нуур хэмээх тойрмыг “шорвог устай нуур” гэж тэмдэглэсэн байдаг. Уг тойромд сүүлийн олон жилийн туршид ус хуримтлагдаагүй байсаар 2018 оны зуны дараалласан их аадар борооны үр дүнд эргээсээ хальж дүүрсэн байна. Энэхүү их хэмжээний ус 2019 оны зуны халуунаар ууршиж алга болсон.

Тавантолгой ордын орчимд байнгын урсгал болоод тогтмол ус байхгүй учраас гадаргын ус хуурай сайрууд болон Улаан нуурт түр хугацаанд үүсч байсан, эс үүсч байсан, хуурай сайруудаар үерийн ус урсаж юмуу, ус тогтож байсан эсэх, хэрэв ус урсаж юмуу тогтож байсан бол хэдий хэмжээний урсац, тогтмол ус үүсч байсан талаар албан ёсны ямар нэгэн мэдээ сэлт байхгүй байна (2009).

2.4 Хөрс

Хөрс газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Говийн мужийн Говийн цайвар бор, Цөлийн бор саарал хөрс бүхий 12-р тойрогт (Манлайн хөрсний тойрогт) багтана. Говийн цайвар бор зонхилон тархах бөгөөд урд хэсгээр Цөлийн бор саарал хөрстэй. Ерөнхий хөрсөн бүрхэвч нь доворхог хад чулуурхаг газрын гадаргын байдлаас шалтгаалж алаг цоог, хоршил зонхилно. Өндөрлөгдүү газраар нимгэн чулуурхаг, хотгордуу газраар ердийн Говийн цайвар бор хөрстэй. Тусгай зөвшөөрлийн талбайн хойд хэсгээр нимгэн чулуурхаг хөрстэй байхад, урд хэсгийн хотгордуу газраар элсэрхэг дов ихтэй элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нилээд их талбай эзэлж байна. Хотгордуу газраар мараалаг хужирлаг шинжийн давсархаг хөрс хам бүрдэл үүсгэж бага зэрэг талбай эзэлнэ.

2.5 Ургамлан бүрхэвч

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг ландшафт-экологийн мужлалаар Дундад говийн муж, Даланзадгадын районд гүвээ толгод бүхий уудам хөндий, хужир марцтай хотгор, цөлөрхөг хээрийн ургамал зонхилсон газар юм. Ургамал бүрхэвч нь газрын гадаргын байдал, хөрсний бүтэц, усан хангамжаас шалтгаалан таана-баглуурт, таана-хялгана, бор бударгана, улаан бударгана зэрэг эвшил бүлгэмдэлээс бүрдэх бөгөөд алтан харгана, дэрс, загсгал, догар, хотир зэрэг сөөг олон наст болон нэг наст өвслөг ургамлууд оролцдог байна. Нийтдээ 13 овгийн 51 төрлийн 75 зүйлийн бүрдэлтэй байна.

2.6 Нийгэм, эдийн засаг

Өмнөговь аймаг нь 2024 оны байдлаар нийт 79211 хүн бүртгэгдсэнээс Цогтцэций суманд 9658 хүн бүртгэгдсэн байна. Уурхайн талбайтай хамгийн ойр орших суурин газар нь Цогтцэций сум юм. Тус сум нь Монгол Улсын өмнөд хилээс 240 км, аймгийн төвөөс 100 км, нийслэл Улаанбаатар хотоос 540 км-т алслагдсан бөгөөд өмнө талаараа Баян-Овоо, баруун талаараа Ханхонгор, хойд талаараа Цогт-Овоо, Дундговь аймгийн Өлзийт сумтай, зүүн талаараа Манлай сумтай тус тус хил залгана.

Хүснэгт 2. 2024 оны хүн амын тоо

Үзүүлэлт	Өмнөговь аймаг	Цогтцэций сум
Хүн амын тоо	79211	9658
Эрэгтэй	39770	4722
Эмэгтэй	39441	4936
Өрхийн тоо	25346	2859

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь орон нутагтай хамтран ажиллах гэрээ, орон нутгын ажилчдыг ажлын байраар хангах ажлын хүрээнд 2024 оны 12 дугаар сарын байдлаар 411 иргэдийг ажлын байраар ханган ажиллаж байна.

Өмнөговь аймаг нь 2024 оны байдлаар 15 сумын 59 багт 1.9 сая толгой мал тоолуулснаас Цогтцэций суманд 134,8 мян толгой мал тоологдсон байна.

Хүснэгт 3. 2024 оны мал тоо. мян.мал

Аймаг, сум	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Өмнөговь	1970.1	84.9	25.2	148.2	541.5	1170.3
Цогтцэций	134.8	9.5	2.1	3	47.2	73.0

Цогтцэций сум нь Өмнөговь аймгийн 15 сум дотроо хамгийн бага буюу 700 гаруй га газар нутагтай. Түүний 16% нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Үүнээс төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХК нь Тавантолгойн бүлэг ордод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Мөн хөрс хуулалт, тээврийн үйл ажиллагаанд 30 орчим туслан гүйцэтгэгч, гэрээт, ханган нийлүүлэгч компаниуд оролцон үйл ажиллагааны эрчимд нөлөөлж байдаг.

Цогтцэций сумын нутаг дэвсгэрт орших Тавантолгой бүлэг ордын үйл ажиллагаа жилээс жилд цар хүрээгээ тэлж олборлолт экспортын хэмжээ нэмэгдэж Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлж буй татвар, хураамжийн хэмжээ өсөн нэмэгдэж Улсын эдийн засгийн хөгжилд оруулж хувь нэмэр оруулан ажиллаж байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааны ашгаас уурхай дагасан томоохон бүтээн байгуулалт – мега төслүүд болох Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, 30 сая тоннын хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэр, усан хангамжийн төслийг санхүүжүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын иргэн бүрд ногдол хувьцааны ноогдол ашгийг олгон ажиллаж байна.

3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

ISO 14001:2016 байгаль орчны менежментийн тогтолцооны стандартын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК нь байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор байгаль орчны асуудлууд тэдгээрээс улбаатай байгаль орчны нөлөөллүүдийг тодорхойлж эрсдэлийн үнэлгээ гүйцэтгэн ажиллаж байна. Эрсдэлийн үнэлгээ нь байгаль орчны гол асуудлыг зөв таньж тодорхойлоход дөхөм болж байгаль орчны чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын ач холбогдлын эрэмбэ дарааллыг тодорхойлох ач холбогдолтой.

3.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц

ISO 14001:2016 стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэв. Байгаль орчны асуудлыг тодорхойлж эдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлж нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг дараах байдлаар тодорхойлов.

Хүснэгт 4. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				
	ялимгүй	бага	дунд	их	гамшиг
I бараг болохгүй	L	L	M	H	H
II магад болохгүй	L	L	M	H	E
III болзошгүй	L	M	H	E	E
IV магад болох	M	H	H	E	E
V лавтай болох	H	H	E	E	E

Хүснэгт 5. Магадлалын үнэлгээний шалгуур

Түвшин	Зэрэг	Тайлбар
I	Бараг болохгүй	Онцгой нөхцөлд эрсдэлтэй байж магадгүй (<5%)
II	Болохгүй байж магад	Заримдаа эрсдэлтэй байж магадгүй (5-20%)
III	Болзошгүй	Заримдаа эрсдэл үүснэ (20-50%)
IV	Магад болох	Бараг бүх нөхцөл эрсдэл үүсгэж болзошгүй (50-70%)
V	Лавтай болох	Бараг бүх нөхцөл эрсдэлтэй (70-100%)

Хүснэгт 6. Үр дагаврын үнэлгээний шалгуур

Зэрэглэл	Уршиг	Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт	Уршигийг бууруулах арилгах шийдэл
----------	-------	--	-----------------------------------

		Хүн ам	Эд хөрөнгө	
I	Ялимгүй	Техноген нөлөө арилахад хор уршиг арилна	Хохирол үгүй	Тусгай шийдэл шаардлагагүй
II	Бага	Бүс нутагт хуримтлагдах нөлөөлөл бий болгож био орчинд стресс учруулна	Багавтар хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн горимыг мөрдөх
III	Дунд	Урт хугацаанд дэлхийн дулааралд хувь нэмэр оруулна	Дунд зэрэг хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн чанд горимыг мөрдөх, зохион байгуулалтын өндөр түвшинд ажиллах
IV	Их	Хуримтлагдах сөрөг нөлөө үүсгэж урт хугацаанд экологийн тэнцвэр алдагдана	Их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил, Тодорхой хэмжээний хөрөнгө зардал шаардана
V	Гамшиг	Байгаль орчинд эргэж буцахааргүй уршиг учруулж экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ	Маш их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил. Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана

3.2 Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээ

	Үйл ажиллагаа	Асуудал	Нөлөөлөл	Хариу арга хэмжээ	Эрсдлийн зэрэг
1. Уурхайн хайгуул, олборлолт, ашиглалтын үндсэн үйл ажиллагаа					
1	Геологийн хайгуулын судалгаа хийх	Өрөмдлөгийн ажил болон зумп үүсгэж газрын хэвлий хөндөгдөх	Хөрсний эвдрэл үүсэх	Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэнэ.	3
		Олон салаа зам гарснаар бэлчээр талхлагдах	Хөрсний эвдрэл үүсэх	Олон салаа замаар зорчихгүй байна.	1
		Ус ашиглах	Усны эх үүсвэр багасах	Усны хэрэглээнд хяналт тавьж, зохистой хэрэглээг хангуулна.	1
2	Хөрс хуулах	Уулын ахилт, мөргөцгөөс олборлох явцад тоосжилт үүсэж агаар бохирдох	Агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх	Агаарт сөрөг нөлөө үзүүлж буй тоосонцорын хэмжилт хийж гүйцэтгэнэ.	4
		Шимт хөрс хуулахгүй байх	Шимт хөрсний нөөц багасах	Холбогдох журмын дагуу Шимт хөрс хуулах зөвшөөрөл олгож, стандартын дагуу хуулах, хадгалах хамгаалах ажилд хяналт тавина.	2
		Биологийн олон янз байдал устгах, дайжих аюул үүсэх	Ургамал, амьтан амьдрах орчин хомсдож хязгаарлагдах	Биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	3
3	Уурхайн ухаш үүсгэх	Газрын хэвлий эвдрэлд өртөх	Газрын чулуулгийн тогтоц өөрчлөгдөх	Хаягдлын овоолго үүсгэж техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийнэ.	3
		Шүүрлийн ус гарах	Хөрсний болон гүний ус хомсдох	Шүүрлийн усыг тоолууржуулж дахин ашиглах талаар арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2
		Уурхай үерийн усанд автах	Уурхайн үйл ажиллагаа алдагдах, зогсох	Үерийн далан, хөв цөөрмийг бий болгох ажлыг зохион байгуулна.	1
4	Тэсэлгээ хийх	Чичиргээ, дуу чимээ үүсэх	Нөлөөллийн бүсийн иргэдийн тав тух алдагдах, зэрлэг амьтад дайжих	Дуу чимээний эх үүсвэрт хяналт, хэмжилт хийн шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1
		Тэсэлгээний бодис тээвэрлэх явцад асгарах	Хөрсний бохирдол үүсэх	Батлагдсан замын маршрутын дагуу аюулгүй ажиллагааг ханган тээвэрлэнэ.	2
		Хөрсний ан цав үүсэх	Газрын чулуулгийн тогтоц өөрчлөгдөх	Технологийн горимыг чанд мөрдөн ажиллана.	2
6	Зам талбайн усалгаа хийх	Ус ашиглах дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглах	Гүний усны нөөц багасах	Гүний усны хэрэглээнд тогтмол хяналт тавина. Гадаргын усыг хуримтлуулан ашиглана.	3

7	Хөрсний овоолго үүсгэх	Газрын гадаргад хаягдал чулуулгийн овоолго үүсгэх	Бэлчээрийн зориулалттай газрын хэмжээ багасах	Биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	3
		Ажиллаж буй техникүүдэд эвдрэл гарч асгаралт үүсэх	Хөрсний бохирдол үүсэх	Техникийн хяналтын тойрох үзлэгийг тогтмол хийнэ.	2
				Асгаралтын хариу арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлнэ.	
2. Техник тоног, төхөөрөмжийн засвар үйлчилгээ					
8	Техник, тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх	Засвар үйлчилгээний үед тосны асгаралт үүсэх	Хөрс болон орчны бохирдол үүсэх	Техникийн үзлэг шалгалтыг сайжруулах, асгаралт үүсэх бүрт бохирдсон хөрсийг зориулалтын талбайруу зөөвөрлөнө.	2
		Засвар үйлчилгээний үед хүчтэй ууршилттай бодис агаарт дэгдэх	Агаарын найрлагад өөрчлөлт орох, хүлэмжийн хий ялгарах, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	ХАЛМ-ийг мөрдөж ажиллах, хадгалалтын нөхцөл горимыг баримтлана.	3
		Чанга дуутай компрессор ажиллуулах	Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл алдагдах	Нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах, чанга дуу чимээ гаргаж төхөөрөмжийг шөнийн цагаар ашиглахгүй байна.	1
		Шатамхай хий, Ферон R134a агаарт дэгдэх	Агаарын найрлагад өөрчлөлт орох, хүлэмжийн хий ялгарах, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Савны битүүмжлэлийг сайжруулж, зориулалтын байранд хадгалж, үзлэг шалгалтыг тогтмол хийж гүйцэтгэнэ.	2
9	Уурхайд ашиглагдаж буй техникүүдээс утаа агаар бохирдуулах	Уурхайн үндсэн, туслах техник болон нүүрс тээврийн хэрэгсэлээс хорт утаа ялгарах	Агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх, хүлэмжийн хий ялгарах	Уурхайн үндсэн, туслах техникийг тээврийн хэрэгслийг улсын үзлэгт хамруулах, нүүрс тээврийн хэрэгслийн бичиг баримтыг шалгаж, хяналт тавина.	3
10	Засвар үйлчилгээнээс хаягдал материал үүсэх	Засварын үйл ажиллагаанаас аюултай хог хаягдал үүсэх	Хөрсний бохирдол үүсэх, Ургамал, амьтны амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх	Аюултай хог хаягдлын бодис хөрсөнд шингэхээс сэргийлж, зориулалтын ангилан ялгах хог хаягдлын түр хадгалах байгууламжтай болж тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад нийлүүлнэ.	3
3. Нүүрсний олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа					
11	Нүүрсний овоолго үүсгэх	Нүүрсний шаталт, уугилт үүсэх	Агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх	Хийн төлөвт агаар бохирдуулагчийн хяналт, шинжилгээг хийж гүйцэтгэнэ.	1
12	Нүүрсний ачилт, тээвэр хийх	Тоосжилт үүсэх	Агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх	Агаарт сөрөг нөлөө үзүүлж буй тоосонцорын хэмжилт хийж гүйцэтгэнэ.	3

13		Нүүрс Тээврийн хэрэгслүүд жолооч нар ачилтанд орох үед ариун цэврийн байгууламж хомс, үүнээс үүдэн ил задгай бие засах, хог хаягдал хаях үүсэх	Хүрээлэн буй орчны бохирдол үүсэх	Хогийн цэг, ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлнэ. Бүх нийтийн цэвэрлэгээнд нүүрс тээврийн жолооч нарыг хамруулан зохион байгуулна.	2	
			Шороон замаар нүүрсний тээвэр хийснээр хөрсний эвдрэл үүсэх	Хөрсний эвдрэл үүсэх	Хатуу хучилттай автозамаар зорчуулахад хяналт тавьна.	3
				Ургамал, амьтан амьдрах орчин хомсдож хязгаардлагдана		
				Тоосжилт үүснэ		
			Нүүрс тээврийн хэрэгсэл ачилтанд орж тээвэрлэлт хийх үед нүүрсний асгаралт үүсэх	Хөрсний бохирдол үүсэх	Нүүрс тээврийн хэрэгслийг бүрэн хучиж, тээврийн хэрэгсэл тус бүр хучлагатай байх шаардлага тавина.	2
Нүүрс тээврийн хэрэгсэлээс гарах тос, хаягдал шингэн бодис	Хөрсний бохирдол үүсэх	Нүүрс тээврийн жолооч нар тээврэлтэд орохын өмнө сайтар техниктэй үзлэг хийж, аливаа гэмтэл байвал засаж нүүрс тээврийн хөдөлгөөнд оролцоход хяналт тавьж ажиллана.	1			
4. Ажилчдын хотхон						
15	Хог үүсэх хаягдал	Уурын зуухны үйл ажиллагаагаар агаарын бохирдол үүсэх	Агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх	Хийн төлөвт агаар бохирдуулагчийн хяналт, шинжилгээг хийж гүйцэтгэнэ.	1	
				Бүх нийтийн мод тарих өдрөөр мод тарина.		
				Барилга байгууламжийн дулааны алддагдлыг бууруулах ажлыг хийж гүйцэтгэнэ.		
		Үнсний хаягдал гарах	Хөрсний болон агаарын бохирдол бий болох	Цацраг идэвхийн хяналт тавьж ажиллана.	1	
		Бохир усны асгаралт	Хөрсний бохирдол үүсэх	Цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээг тогтмол хийнэ.	2	
				Цэвэршүүлсэн бохир усны хянал шалгалтыг тогтмол хийнэ.		
		Лаг шаварны хаягдал үүсэх	Хөрс бохирдох, Агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх	Үүсэж лаг шаврыг тогтмол соруулж, лагийн талбай байгуулна.	1	
Энгийн хог хаягдал үүсэх	Хөрсний бохирдол үүсэх	Хог хаягдлын ангилан ялгалтын сав шаардлагатай цэгүүдэд байршуулна. Хог хаягдлын ангилан ялгалтыг хийж, лааз, хуванцар савыг дахин үйлдвэрт нийлүүлнэ.	2			

				Хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэнэ. Хог хаягдлын гарцын хяналт тавина. Худалдан авалтын чанарт анхаарч эдэлгээ сайтай чанартай бүтээгдэхүүн худалдан авахад анхаарна.	
16	Хоол үйлдвэрлэл, цэвэрлэгээ үйлчилгээ үзүүлэх	Хоолны хог хаягдал үүсэх	Хөрсний бохирдол үүсэх	Хоолны хаягдал, цэвэрлэгээнээс гарах бодисын сав баглаа боодлын ангилан ялгаж, гарцын хяналт тавина. Хоолны хаягдлаар бордоо бэлтгэнэ.	1
18	Цахилгааны шугам	Шувуу тогонд цохиулж хорогдох	Шувууны тоо толгой багасах	Шувуу үргээгч суурьлуулна. Амьтны мониторингийг тогтмол хийж гүйцэтгэнэ.	1
5. Орон нутагтай хамтран ажиллах үйл ажиллагаа					
19	Орон нутагтай хамтран ажиллах	Бэлчээрийн хомсдол үүсэх	Мал аж ахуй эрхлэхэд хүндрэл үүсэх	Нөлөөлөлд өртөж буй айл өрхийг нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгоно.	3
		Усны түвшин буурах	Амьдрах орчин хязгаарлагдах	Гүний худаг гаргаж, сэргээн засварлана.	2
		Тоосжилт үүсэх	Эрүүл мэндээрээ хохирох	Агаарын чанарын хөндлөнгийн хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.	2
		Чичиргээ, дуу чимээ үүсэх	Эрүүл мэндээрээ хохирох	Хамтын оролцоот мониторингийг хийх	1

4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгой нүүрсний орд газар дахь ил уурхайн үйл ажиллагаанд байгаль орчны нийцлийг хангуулах гол зорилготой.

Төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорилт болгоно. Үүнд:

- ISO 14001:2015 байгаль орчны менежментийн тогтолцооны стандартын хүрээнд тасралтгүй сайжруулалтын хийх, хэрэгжүүлэх
- Байгаль орчны аудит, БОННУ-ний шаардлагуудыг биелүүлэх.
- Компанийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.
- Гэрээт байгууллагуудын байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, түүний гүйцэтгэлд хяналт тавих, аргазүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах,
- Уурхайн үйл ажиллагааны талбайн хүрээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангуулахад анхаарч ажиллах
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн хэмжээнд байгаль орчны бодлого, дүрэм, журмыг хэрэгжилтийг хангах
- Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглалтын байдалд хяналт тавьж төрийн болон хяналтын байгууллагуудад мэдээ хүргэх.
- БОМТ-нд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг тодорхойлох.
- ОХШХ-нд талуудын оролцоог хангах, ил тод нээлттэй байх зарчмыг баримтлах.

5 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагааны явцад ил уурхайд хөрс хуулалт, тэсэлгээ хийх, нүүрс олборлолт, нүүрс ачих, буулгах, хаягдал чулуулаг ба хөрсийг ачиж тээвэрлэх, овоолго үүсгэх, гаалийн талбайн үйл ажиллагаа зэрэг олон төрлийн эх үүсвэрээс агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байдаг. Эдгээр эх үүсвэрүүдээс агаарын чанарт нөлөөлж буй сөрөг нөлөөллүүдийг бууруулахын тулд дараах 8-н арга хэмжээ гэрээт туслан гүйцэтгэгч байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн уулын цул тээвэрлэх үйл ажиллагаанаас агаарт тоосжилт бий болох	Тоос бууруулах зорилгоор хөрс барьцалдуулагч бодисыг технологийн замд ашиглана.	Уурхайн технологийн зам	15 км	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	Агаарын тухай хууль, Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016)
2	Уурхайн олборлолтын ажиллагаанаас агаарт тоосжилт бий болох	Уурхайн технологийн зам арчилгааны төлөвлөгөө шинэчлэн сайжруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Уурхайн технологийн зам, талбай	15 км	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	Агаарын тухай хууль, Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016)
3		Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн хяналтын талбайд усалгааны авто машиныг тогтмол ажиллуулна.	Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн хяналтын талбай	5-аас доошгүй	Жилийн турш		
4		Уурхайн дотоод зам талбайд шороон зам дээгүүр зорчиж буй хөнгөн тэрэг болон уулын машин механизмуудад хурдны хязгаар тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийж, хяналт тавьж ажиллана.	Уурхайн технологийн зам	Сард 3	Жилийн турш		

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
5	Хотхон уурхайг холбосон шороон замаас тоосжилт бий болох	Ачаа тээврийн авто машинуудыг хатуу хучилттай авто замаар зорчуулах тал дээр хяналт тавьж ажиллана.	Кемп хоорондын шороон зам болон ачаа тээврийн сайжруулсан шороон зам	2.9 км	Жилийн турш		
6	Нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас нүүрсний тоосонцор дэгдэж, агаарын бохирдол үүсэх	Нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээнэ.	Нүүрс ачилтын талбай	Тогтмол	Жилийн турш	-	Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016) ЭТТ-СА-ГО41-БО-ГО07-X02 ¹
7	Уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрийн шаталтаас агаарын бохирдол үүсэх	Уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулна.	Уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгсэл	-	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УИХ-ын тогтоол 2011.01.06)
8	Агаарын чанарт нөлөөлөх байдлын хяналт алдагдах	Агаарын чанарын хяналтын станцын тоог нэмэгдүүлнэ.	Төслийн хэмжээнд	3	Жилийн турш	150.0	2024.12.02-ны өдрийн 2025 оны БОМТ-нд тусгах санал
	Нийт					150.0	

5.2 Гадаргын ба газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаар нийт 8-н ажил төлөвлөсөн ба газрын доорх усны чанар болон нөөцөд өөрчлөлт үзүүлж байгаа эсэхд байнгын хяналт тавих, усны эх үүсвэр бохирдохоос сэргийлж худгийн хэвийн үйл ажиллагааг ханган Монгол улсын хууль, журмыг мөрдлөг болгон ажиллана. Мөн гадаргын усны нөөцийг хамгаалах зорилгоор сум орон нутгийн малчдаас санал авч нөлөөллийн бүсийн булгийн эхийг холбогдох шаардлагад нийцүүлэн хашиж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөв.

²¹ Агаарын чанарын хяналт хийх горим.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Газрын доорх усны бохирдол үүсэх	Ашиглалтын худагуудад бохирдол үүсэхээс сэргийлэн холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавина.	Эзэмшлийн худгууд	Нийт худаг	Жилийн турш	-	Ус ашиглалтын журам ЭТТ-СА-Ж38-БО-Ж11-Х01
2	Уурхайн хэрэгцээнд газрын доорх усны нөөцийг ашигласнаар усны нөөц багасах	Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох журмын дагуу авч, ус ашиглах гэрээ байгуулан ажиллана.	Уурхайн хэмжээнд	1	2025 он	6.5	Усны тухай хууль
3		Усны нөөц ашиглуулах дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ашиглах, ус ашигласны төлбөр хураамжыг төлж барагдуулна.	Уурхайн хэмжээнд	12	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	Усны тухай хууль
4		Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох журмын дагуу авч, гэрээ байгуулан ажиллана.	Цэвэрлэх байгууламжууд	4	Улирал бүр	Үйл ажиллагааны зардал	Ус бохирдуулсны тухай хууль
5		Хаягдал усыг стандартын шаардлага хангасан цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэн саарал ус гаргаж зам талбайн тоосжилт дарах, мод усалгаанд ашиглана.	ЭТТ, гэрээт компаниуд	Тодорхойлох боломжгүй	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус MNS 4943:2011
6		Газрын доорх усны нөөц, чанарт тогтмол хяналт тавина.	GW713, №21, 11-р цооног	3	Жилийн турш	35.8	Усны тухай хууль

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
7		Ус ашиглалтын бүх эх үүсвэрээс ашиглах усны хэмжээг зөв тодорхойлох зорилгоор тоолууржуулна.	Ашиглалтын худгууд, шүүрлийн ус		Жилийн турш	1.0	Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам
	Нийт					43.3	

5.3 Хөрсөн бүрхэвчид нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь цөлөрхөг хээр (говийн) болон цөлийн бүсэд харин зүүн талдаа хуурай хээрийн бүсэд хамрагдах бөгөөд хөрс үүсвэрийн нөхцөл нь тухайн газар нутгийн онцлог, байгаль цаг уурын нөхцөлөөс хамаарч үржил шим ядуутай, ялзмагийн агууламж багатай, ялзмагийн хуримтлалын давхарга нимгэнтэй хөрсний төрлүүд голлон тогтворжсон байдаг.

Иймд уурхайн ахилт, овоолгын тэлэлт зэрэг газар хөндөх үйл ажиллагаа бүрт компанийн ЭТТ-СА-Ж14-БО-Ж09-Х03 Өнгөн хөрстэй ажиллах журам, ЭТТ-СА-Ж11-БО-Ж07-Х03 Газар хөндөх журмын дагуу шимт хөрсийг хуулах, тусдаа овоолго үүсгэн хадгалах, удаан хугацаагаар хадгалах овоолгуудын үржил шимийг алдагдуулахгүй байх арга хэмжээг төлөвлөх, уурхайгаас гадуур олон салаа зам гарч хөрс элэгдэх зэрэг хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлуудыг хийхээр төлөвлөөд байна. Цанхийн баруун, зүүн уурхайд 2024 оны жилийн эцсийн байдлаар 5,735.1 мян.м³ шимт хөрс хадгалагдаж байна.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн хэмжээнд хөрсний доройтол бохирдол үүсэх	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимын мөрдөлтийг хангуулан хяналт тавьж ажиллана.	Уурхайн хэмжээнд	12	Сар бүр	-	Уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн хяналт хийх журам ЭТТ-СА-Ж05-БО-Ж01-Х02
3	Тусгай зөвшөөрлийн талбайд зөвшөөрөлгүй ААН үйл ажиллагаа явуулж хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүсгэх	Тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн судалгааг хийж Сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай хамтран зөрчил арилгах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Тусгай зөвшөөрлийн талбай	1	Жилд	-	Уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн хяналт хийх журам ЭТТ-СА-Ж05-БО-Ж01-Х01

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
4	Ил уурхайн ахилт, овоолгын тэлэлтэд шимт хөрс өртөх	Ахилтад өртөх талбайн шимт хөрсийг >0.3 метр зузаантай хуулж, стандартын дагуу хадгална.	Тусгай зөвшөөрлийн талбай	Тухай бүр	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	Газрын тухай хууль, MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
5		Шимт хөрсний хаагдсан овоолгуудад стандартын шаардлагын дагуу хяналт тавьж, акт үйлдэнэ.	Уурхайн хэмжээнд	-	Жилийн турш	-	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
6		Шимт хөрс хуулах зөвшөөрлийг тухай бүр олгож холбогдох журмын дагуу овоолгод байршуулна.	Уурхайн хэмжээнд	-	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	
7	Авто машины хөдөлгөөнөөр хөрсний элэгдэл үүсэж бэлчээр талхлагдах	Гэрээт байгууллагуудын ажилчдын хотхон – Уурхай чиглэлд зорчих замын маршрутыг гаргаж, мөрдүүлнэ.	Уурхайн хэмжээнд	Гэрээт байгууллагуудын хотхонууд	Жилийн турш	-	БОННУ, БОМТ-нд тусгагдсаны дагуу
8	Хөрсний нянгийн бохирдол үүсэх	Хөрс бохирдохоос сэргийлж Цогтцэций сумын төвийн зорилтот бүлгийн зарим өрхөд эко жорлон суурилуулна.	Цогтцэций сум	30	Жилийн турш	-	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
9		Ажилчдын хотхоны хог хаягдлын цэгт бактерийн бохирдлоос сэргийлж ариутгал хийнэ.	Ажилчдын хотхон	4	Улирал бүр	2.0	Уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн хяналт хийх журам ЭТТ-СА-Ж05-БО-Ж01-Х02

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
	Нийт					2.0	

5.4 Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайн хэмжээнд газар хөндөх бүх арга хэмжээг компанийн ЭТТ-СА-Ж11-БО-Ж07-Х03 Газар хөндөх журмаар зохицуулан бүртгэлжүүлж ажиллаж байна. Газар хөндөх зөвшөөрлийг газрын хэвлийг хөндөж буй бүх үйл ажиллагааны үед авах ба холбогдох сүлжээний, цахилгааны, сантехникийн, хөдөлмөрийн аюулгүй байдлын, байгаль орчны инженерүүдээр гарын үсэг зуруулан баталгаажуулж үйл ажиллагааг эхлүүлэн ажилладаг.

Мөн лицензийн талбайд үйл ажиллагаа явуулж буй түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж буй байгууллагуудад хяналт тавин ажиллахаар төлөвлөж байна.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Олборлолтын улмаас газрын хэвлий эвдрэх, нөлөөлөлд өртөж доройтох	Зөвшөөрөлгүй газар хөндөхөөс сэргийлж, аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл олгож хөндөгдсөн газрын бүртгэлийг мэдээллийн санд бүртгэнэ.	Тусгай зөвшөөрлийн талбай	Олгосон Зөвшөөрлийн тоо	Тухай бүр	-	MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн "Газар хөндөх" журам
2		Тусгай зөвшөөрлийн талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-н судалгаа хийж хяналт тавьна.	Тусгай зөвшөөрлийн талбай	-	Жилд 1 удаа	-	Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай
	Нийт					-	

5.5 Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд 2024 оны байдлаар нийт 22 овог, 56 төрөл, 72 зүйл ургамал бүртгэгдсэн байдаг /“Гарааны ногоон дэлхийн чанар” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Ургамлын хөндлөнгийн мониторингийн тайлан/. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд нийт 6 трансектын дагуу 24 цэгт ургамлын мониторингийн ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн ахилт, тэлэлтэд ховор болон нэн ховор ургамал өртөх	Уурхайн ахилтанд өртөж болзошгүй ховор болон нэн ховор ургамлын байршлыг тогтоож, мэдээллийн санд оруулах, өртөх тохиолдолд шилжүүлэн суулгана.	Тухайн жилийн ахилтын хүрээ	2 удаа	6-8-р сарын хооронд	-	Ургамал хамгааллын тухай хууль, Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Газар хөндөх болон ховор, нэн ховор ургамлыг хамгаалах журам
2	Нутгийн ургамал ховордох	Нутгийн ургамлыг таниулах зорилго бүхий экологийн боловсрол олгоно.	Цогтцэций сумын ЕБС	2-с багагүй	9-10 сар	3.0	Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр
	Нийт					3.0	

5.6 Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Тавантолгойн нүүрсний бүлэг уурхайн олборлолтын явцад тухайн орчны ан амьтан дайжсан бөгөөд цаашид уг төсөл хэрэгжих хугацаанд амьтны аймагт дараах болзошгүй сөрөг нөлөөллүүдийг үзүүлнэ. Үүнд:

- Уурхайн тэсэлгээ, дуу чимээ, гэрэлтүүлэг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс зэрлэг амьтад уурхайн орчмоос дайжих;
- Уурхайн нүх, ухааш, нүх шуудуунд мал, амьтан орж үрэгдэх;
- Нүүрсний ордыг олборлох үйл ажиллагаагаар эвдэрсэн талбайн хэмжээгээр өвсөн тэжээлт амьтдын бэлчээр нутаг багасах;
- Уурхайд ажиллахаар олноор ирж буй хүмүүсийн тоо нэмэгдэх, улмаар урхи, хавх тавих зэргээр хууль бусаар ан хийх.

Тус нөлөөллүүдийг харгалзан үзэж тус онд дараах ажлуудыг хийхээр төлөвлөв.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Нутгийн зэрлэг амьтдын тоо толгой буурах	Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрч зэрлэг амьтдын идэш тэжээл ховордох үед хужир, долооц, мөс, өвс тэжээл байршуулан биотехникийн арга хэмжээг зохион байгуулна.	Цогтцэций сум	>500 боодол	1 дүгээр улиралд	6.0	Амьтны тухай хууль, Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр, Орон нутагтай хамтран ажиллах хамтын ажиллагааны гэрээ
2		Зэрлэг амьтдад зориулсан ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулна.	Цогтцэций сум	2 ширхэг	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	
3	Өндөр хүчдэлийн шугаманд шувуу өртөх	Шувууны өртөлтийг багасгах зорилгоор өндөр хүчдэлийн шугамын трассаар хяналт хийж ажиллана.	Уурхайн хэмжээнд	50 км	2-3 дугаар улиралд	-	Амьтны тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
4	Хууль бус хулгайн ангийн улмаас ан амьтад хорогдох	“Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудад хулгайн ангаас сэргийлэх хууль эрхзүйн сургалтыг Цогтцэций сумын экологийн цагдаатай хамтран зохион байгуулна.	Төслийн хэмжээнд	>500 хүн	Жилд 1 удаа	1.0	
	Нийт					7.0	

6 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал, сая ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Шартээг-13.5км автозамыг холбосон 2.9км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсны дараа хуучин шороон замыг нөхөн сэргээнэ.	ЭТТ, гэрээт компаниуд	га	2.3	I-II улиралд	Үйл ажиллагааны зардал	Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал” (MNS 5915:2008) Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт (MNS 5916:2008) Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага” (MNS 5917:2008)
2		Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто зам дагуу 0-25 дахь км хүртэлх замын хажуугаар олон салаа шороон зам үүсэхээс сэргийлсэн шороон далан, шуудууг нөхөн сэргээнэ.	ЭТТ, гэрээт компаниуд	га	1	II-III улиралд		
3		Шартээг-13.5км автозамыг холбосон 2.9 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсны дараа Баруун нарангийн авто замаас салаалсан ачаа тээврийн 7.4 км шороон замыг хэсэгчлэн нөхөн сэргээнэ.	ЭТТ, гэрээт компаниуд	га	7.4	II улиралд		
4	Биологийн нөхөн сэргээлтийн бэлтгэл үе шат	Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст өвслөг ургамал тариална.	Уурхайн хэмжээнд	га	>3	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс, хуулалт, хадгалалт MNS 5917:2008. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага.

5		Модлог ургамлын үрийн нөөц бүрдүүлнэ.	ЭТТ, Гэрээт компаниуд	кг	>10	Жилдээ	16.0	Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6-д Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана” гэх заалт
6		Модлог ургамлын мөчир бэлтгэнэ.	ЭТТ, Гэрээт компаниуд	ш	>2000	I улирал		
7		Хүнсний ногооны хаягдал ашиглан био компост бордоо бэлтгэнэ.	Мод үржүүлгийн “Эрдэнэс агропарк”	кг	>500	Жилдээ	-	
8		Модлог ургамлыг үр, мөчир хэлбэрээр үржүүлнэ.	Мод үржүүлгийн “Эрдэнэс агропарк”	ш	>20000	Жилдээ	123.2	Тэрбум мод үндэсний хөтөлбөр, Сая тонн-Сая мод хөтөлбөр
	Нийт						139.2	

7 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ

7.1 Биологийн олон янз байдал талаар баримтлах бодлого

Дүйцүүлэн хамгаалах газар нутгийг тогтоохдоо уурхайн олборлолтын үйл ажиллагаа идэвхтэй явагдаж буй талбай болон нөлөөлөлд өртсөн талбайгаас ойр байх экологийн хувьд дүйцэхүйц байх зарчмыг баримтална². 2019 онд уурхайн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх талбайн хэмжээг тодорхойлсны үндсэн дээр дүйцүүлэн хамгаалах талбайн хэмжээг тогтоосон бөгөөд Өмнөговь аймгийн Байгалв орчны газар болон сумын ЗДТГ-т танилцуулан дүйцүүлэн хамгаалал явуулах талбайн байршлыг тогтоосон. Дүйцүүлэн хамгаалахаар тогтоосон газар нь 28км өргөнтэй, 36км урттай нийт 99000га талбайг хамрах бөгөөд Цагаан-Овоо, Билгэх багийн нутгийг дамнан оршино.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ нөлөөллийг бууруулах шатлал буюу зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах зарчмыг баримтлана.



2019 оноос хойш тус талбайд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр холбогдох ажлуудыг мэргэжлийн байгууллагаар шат дараатайгаар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 2025 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

² Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А-11 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал

7.2 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал, сая ₮
1	Амьтны олон янз байдлыг хамгаалах	Махчин шувууд суух боломжтой хиймэл үүр суурилуулах	Дүйцүүлэн хамгаалах газар нутагт	ш	5	Жилдээ	350.0
2		Хууль бус хулгай антай тэмцэх ажлын хүрээнд орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах		-	-	Жилдээ	
3		Амьтны камерын өгөгдөлийг цуглуулан боловсруулж, дүн шинжилгээ хийх		ш	3	Жилдээ	
4		Зүүнбаян чиглэлийн Төмөр замын орчимд хар сүүлтийг хүзүүвчлэн тандан судалгаа гүйцэтгэх		ш	1	Жилдээ	
5	Ургамлын олон янз байдлыг хамгаалах	Байгалийн ургамлыг таних, хамгаалах, зөв зохистой ашиглах талаар сургалт, дадлага зохион байгуулах	Дүйцүүлэн хамгаалах газар нутагт	удаа	2	II-III улиралд	
6		Дүйцүүлэн хамгаалах талбайд тогтоосон бэлчээрийн хяналтын мониторинг хийх		цэг	12	Жилдээ	
7		Говийн мод, сөөгний тарьц суулгац бэлтгэх талбайг арчилж хамгаалах		га	3.2	Жилдээ	
8		Хөрсний шинж чанар, элэгдэл эвдрэл, физик болон хими шинж чанарыг тодорхойлох зорилгоор дээж авч, хөрсний бичиглэл хийх, зураг боловсруулах, доройтлын хүчин зүйлийг тодорхойлох				Жилдээ	

9	Уст цэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах	Ус хангамжийг сайжруулах зорилгоор булгийн эхийг хашиж хамгаалах	Дүйцүүлэн хамгаалах газар нутагт	ширхэг	1	Жилдээ	
10		Өмнө жилийн дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн зэрлэг ан амьтны худгийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих		ширхэг	2		
11	Дүйцүүлэн хамгаалах талбайг нэмэгдүүлэх	НБҮ, ЗУХ-н төслүүдийн цар хүрээнд дүйцүүлэн хамгаалах талбайн хэмжээг орон нутагтай хамтран ажиллаж тогтоох	-	-	-	Жилдээ	
	Нийт						350.0

8 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Өмнөговь аймгийн нутгийн захиргааны байгууллагатай Цагаан-Овоо багийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар ханган, иргэдийн хөрөнгийн нөхөн олговрыг олгох, газар чөлөөлөх ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, Цагаан-Овоо багийн иргэдийг нүүлгэн шилжүүлэхэд хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулан хамтран ажиллаж байна. Нөхөн олговрын ажил 2021 оноос эхлэн хийгдэж байгаа бөгөөд нийт хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн 267 иргэнд нөхөн олговор олгож нүүлгэн шилжүүлэхээс 251 иргэнтэй гэрээ байгуулсан 2024 оны байдлаар гүйцэтгэл 94 хувьтай явагдаж байна. 2025 онд дараах иргэдийн хөрөнгийн нөхөн олговрыг олгож газар чөлөөлөх ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахаар төлөвлөсөн.

№	Нөлөөлөлд өртөх иргэд,	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	Нийт зардал сая ₮
1	Цагаан-Овоо баг	Цагаан овоо багийн иргэдтэй нөхөн олговрын гэрээ байгуулан нөхөн олговор олгож газар чөлөөлөх	Цагаан-Овоо багийн иргэд	16 иргэн	2025 онд	Өмнөговь аймгийн ЗДТГ болон “Эрдэнэс Тавантолгой” ХК хооронд 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан ЭТТ-2021/407 дугаартай “Хамтын ажиллагааны гэрээ”, ЭТТ-2021/810 дугаартай “Цагаан-Овоо багийн иргэдийг нүүлгэн шилжүүлэхэд хамтран ажиллах гэрээ, Нийгмийн хариуцлагын бодлогын баримт бичиг” Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, ЗГ-ын 182 тогтоол	Тодорхойлох боломжгүй

ЖИЧ: “ЭТТ” ХК-ийн нөхөн олговор олгох санхүүжилтийн асуудлаас шалтгаалаагүй иргэдийн Хөрөнгийн үнэлгээний маргаан, шүүхийн асуудал зэрэг хүчин зүйлийн улмаас гүйцэтгэл бүрэн хангагдахгүй байх эрсдэлтэй.

9 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2015 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/141 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Соёлын өвийн судалгаа хийх журам”-д нийцүүлэн археологи, палеонтологийн хайгуул, авран хамгаалах судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бөгөөд Цанхи болон Бортээгийн хэсэгт археологийн авран хамгаалах малтлага судалгаа хийж талбайг чөлөөлсөн.

2021 онд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн захиалгаар “Цанхийн зүүн уурхай” MV-011953А, “Шар тээг” MV-011955А, “Бор тээг” MV-011954А талбайд ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн судлаачдын баг археологийн хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус судалгааны үр дүнгээр нийт 30 дурсгал илрүүлснийг 2025 онд Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох журмын дагуу авран хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн талбайг чөлөөлнө.

№	Түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	Нийт зардал, сая ₮
1	Соёлын өвийн талаар мэдээлэл түгээх	Соёлын өвийг хамгаалах талаар уурхайн ажилчдад таниулах, энэ чиглэлээр хийгдсэн ажлуудыг танилцуулах.	Төслийн үндсэн болон гэрээт компанийн ажилчид	Жилдээ	Соёлын өвийн тухай хууль	-
2	Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх талаар	Үндэсний шагайн харвааны салбар зөвлөлийн тэмцээн зохион байгуулах	Цогтцэций суманд зохион байгуулах	III улиралд	Соёлын өвийн тухай хууль	51.7
3	Цогтцэций сумын 9 гайхамшигт орсон “Цавчирын задгай”	Цогтцэций сумын 9 гайхамшигт орсон Цавчирын задгайг тохижуулах	Цогтцэций суманд	II,III улиралд	Цогтцэций сумын ИТХ-ийн тогтоол	2.0
	Нийт					53.7

10 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн бүхий л үе шатанд тохиолдолж болзошгүй осол, аюул, эрсдэлүүдийг дараах байдлаар урьдчилан тодорхойлж, тодорхойлсон. Үүнд:

- ✓ Үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас үүсэх эрслэл
- ✓ Аюултай бодис асгарах
- ✓ Байгалийн гамшигт үзэгдэл
- ✓ Гал түймэр гарах

Мөн энэхүү дэд бүлгийн үндсэн зорилго нь уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй бүхий л төрлийн химийн найрлага бүхий бодисыг бүрэн бүртгэлжүүлэн, бодис тус бүрээр тухайн бодисын хор аюулын лавлах мэдээллийг боловсруулан хүн болон хүрээлэн буй орчинд учруулж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, эрсдэл үүссэн тохиолдолд авах арга хэмжээг тодорхойлох явдал юм.

Дараах бичиг баримтыг мөрдлөг болгон ажиллана. Үүнд:

- ✓ Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөө
- ✓ Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө
- ✓ Асгаралтын журам

2025 онд осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг тодорхойлж, хэрэгжүүлнэ.

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал, сая ₮	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Нүүрс устөрөгч, химийн бодис асгарах	ХАЛМ болон асгаралтын иж бүрдлийг шаардлагатай ажлын байранд байршуулах	Уурхайн хэмжээнд	Цэг	10-аас доошгүй	Жилдээ	44.7	Асгаралтын журам
2		Тусгай бэлдсэн талбайд бохирдсон хөрсийг байршуулах		Тодорхойлох боломжгүй		Тухай бүр	Үйл ажиллагааны зардал	
3		Бохирдсон хөрс саармагжуулах талбайг стандартын дагуу шинээр байгуулах		Ширхэг	1 талбай	Жилдээ	60.0	
4		Асгаралтыг бүртгэлжүүлж мэдээллийн сан үүсгэх		-	-	Жилдээ		
5		Асгаралтын журмыг шинэчлэн сайжруулах, батлуулах		Удаа	1	Жилдээ		

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал, сая ₮	Баримтлах эрх зүйн баримт бичиг
6	Байгалийн аюул, гамшиг нөхцөл байдал	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	Уурхайн хэмжээнд	Удаа	1	Жилдээ	Үйл ажиллагааны зардал	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017
7		Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг нийт ажилтнуудад танилцуулах	Уурхайн хэмжээнд	-	>800 хүнд	Жилдээ		
8		Үерийн эрсдэл бүхий цэгүүдэд байгуулсан ус зайлуулах суваг шуудууг сэргээх	Уурхай, хотхоны хэмжээнд	-	-	Жилдээ		Усны тухай хууль, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм, БНБД-30.01.03
9	Гал түймрийн аюул эрсдэл	Галын аюулгүй байдлын журамд тодотгол хийж, түүнийг дагаж мөрдөх	Уурхайн хэмжээнд	-		II,III улиралд	-	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017
10		Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалын заасан самбар галын аюул болж болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байрлуулах, хяналт тавих	Уурхайн хэмжээнд	-	100	Жилдээ	-	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал, сая ₮	Баримтлах эрх зүйн баримт бичиг
11		Шатахуун түгээх станцын талбайд ил гал гаргахыг хориглосон, анхааруулсан тэмдэг, санамж байрлуулах, үерээс хамгаалсан суваг, шуудууг татах, сэргээх	ШТС-ын талбай	ш	5	Жилдээ	Үйл ажиллагааны зардал	Гамшгаас хамгаалах тухай хууль, MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем, галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага.
12	Байгаль орчинд учруулж болзошгүй эрсдэл	Хөрсний нуралтаас урьдчилан сэргийлэхийн тулд ил уурхайн хөрс хуулалт, шатлал, ухалт, тэсэлгээ зэрэг ажлуудыг гүйцэтгэхдээ холбогдох дүрэм журмыг мөрдөж ажиллах	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд	-	-	Жилдээ	-	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995
	Нийт						104.7	

11 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаас хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах зорилгоор хог хаягдлын зохистой удирдлагыг хэрэгжүүлэн ажиллана.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг энэхүү төслийн талбай дээр үйл ажиллагаа явуулж буй үндсэн болон гэрээт байгууллагууд нийтээр дагаж мөрдөх үүрэгтэй.

№	Ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Нийт зардал, сая ₮	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Бүх төрлийн хог хаягдал	Хог хаягдлын нэгдсэн төв, ландфил байгуулах зураг төслийн ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Төслийн хэмжээнд	10 га талбайд	III улиралд	250.0	Хог хаягдлын тухай хууль
3		Хог хаягдлын журмыг шинэчлэх боловсруулж, дагаж мөрдүүлэх	Төслийн хэмжээнд	-	III улиралд	-	
4		Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилал тус бүрээр 2 дахь шатны байгууллагад нийлүүлэх	ЭТТ ХК болон гэрээт байгууллагууд	-	Жилдээ	16.8	
5		Ангилан ялгасан хог хаягдлын хяналтыг сайжруулах, бүртгэлжүүлэх	Төслийн хэмжээнд	Нэгж тайлан	Жилдээ	-	
		Хоолны хаягдлаар бордоо хийх туршилт судалгааны ажлыг гүйцэтгэх	ЭТТ ХК	-	Жилдээ	Үйл ажиллагааны зардал	
6		Хоолны хаягдал үүсгэхгүй байхад чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулах	Төслийн хэмжээнд	2 удаа	Жилдээ	Үйл ажиллагааны зардал	
7	Аюултай хог хаягдал	Гэрээт компаниудын хаягдал тос, аюултай хог хаягдал түр хадгалах цэгийн стандартын шаардлагыг хангуулах	Төслийн хэмжээнд	Бүх компаниуд	III улиралд	Үйл ажиллагааны зардал	

8		ЭТТ ХК-ийн Хаягдал тосны байгууламжийг стандартад нийцүүлэх	Засварын талбай	1	Жилдээ		Хог хаягдлын тухай хууль
9		Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй ААН-д шилжүүлэх, тээвэрлүүлэх	ЭТТ ХК болон гэрээт байгууллагууд	>5 удаа	Жилдээ	60.5	
10		Аюултай хог хаягдлыг нийлүүлсэн тусгай зөвшөөрөлтэй ААН-ээс хог устгалын тайлан, дагалдах хуудас зэргийг авч, мэдээллийн сан үүсгэх	ЭТТ ХК болон гэрээт байгууллагууд	Тухай бүр	Жилдээ	-	
11		Аюултай хог хаягдал үүсгэгчийн тайлан боловсруулж, аймгийн байгаль орчны газарт хүргүүлэх	Төслийн хэмжээнд	1 удаа	Жилдээ	-	
12	Бүх нийтийн цэвэрлэгээ, хяналт шалгалт	Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто замын 0-25 дахь км зам дагуу талбайн үзлэгийг тогтмол зохион байгуулж, хяналт тавих	Нүүрс тээврийн зам	12 удаа	Жилдээ	Үйл ажиллагааны зардал	Хог хаягдлын тухай хууль
13		Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто замын 0-25 дахь км зам дагуух хог хаягдлын цэвэрлэгээг сар бүр хийж, тайланг БОГ болон сумын ЗДТГ-т хүргүүлэх.	Нүүрс тээврийн зам	12 удаа	Жилдээ		
14		Сум орон нутгаас зохион байгуулж буй хог хаягдлын цэвэрлэгээнд оролцох	Орон нутаг	Тухай бүр	Жилдээ		
15		Уурхай болон сум-хотхон хоорондын авто зам дагуу хог хаягдлын цэвэрлэгээ хийх	Төслийн хэмжээнд	4	Улирал бүр		
16		Хог хаягдлын цэгүүдэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах.	Төслийн хэмжээнд	12 удаа	Жилдээ		
	Нийт					327.3	

12 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Цанхийн баруун, зүүн уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг шинжлэх ухааны үндэслэлтэй аргачлал, стандартаар хянаж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоосноор түүнийг эдийн засгийн хэмнэлттэй арилгах арга хэмжээг оновчтой тодорхойлох үндсэн зорилготой.

Энэ зорилгын хүрээнд хөрс-ургамал, агаар, усан орчинд үзүүлэх нөлөөллийг хянахад хэмжилтийн багаж төхөөрөмж ашиглах, тэдгээрийн калибраци, тохиргоог хангах, дээж авах зааварчилгаа болон лабораторид дээж хүргэн шинжлүүлэх горимыг мөрдүүлэх, усны хэрэглээ, хог хаягдлын гарц урсгалын хяналтыг бүртгэлжүүлэх цогц зорилтуудыг тавьж ажиллах юм.

12.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ

Агаарын чанарын хяналт шинжилгээг дараах чиглэлүүдийн дагуу хийж гүйцэтгэх ба хэмжилтийн үр дүнг Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 стандарттай харьцуулан дүгнэлт гаргана.

1. Гадаад агаарын аерозолын хэмжилт
2. Хийн төлөвт агаар бохирдуулагчийн хэмжилт
3. Тоосонцорын агууламж дахь хүнд металлын хэмжилт
4. Дуу чимээний хэмжилт
5. Цацрагийн хэмжилт

Аерозолын хэмжилтийг шууд хэмжилтийн аргаар явуулах ба 2018 оноос хойш долоо хоногт 3 өдөр тус бүр 20-оос багагүй цагийн үргэлжлэлтэйгээр, 2021 оны 2-р хагас жилээс тоосонцорын хэмжилтийг 7 цэг дээр тасралтгүй зарчмаар буюу 7 хоног тутам цэг тус бүр дээр нийт >96 цагийг үргэлжлэлтэйгээр тус тус гүйцэтгэж байна.

2025 онд гэрээт туслан гүйцэтгэгч компаниудтай хамтран >5 цэгт тоосонцорын хэмжилтийг хийж гүйцэтгэх ба 7 хоногт дунджаар нэг цэгт 60-аас багагүй цагийн хэмжилт хийнэ. Хэмжилтийг хийж гүйцэтгэхдээ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Агаарын чанарын хяналт хийх горим”-ыг мөрдлөг болгоно.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, сая.₮	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Аерозол: PM2.5, PM10, нийт тоосонцор	Уурхайн бүсийн 5 цэг, хяналтын 1 цэг	Жилийн турш (3500 цаг/жил).	7 хоногт >60 цаг	12.3	Үйл ажиллагааны зардал	Үйлдвэрийн тохиргоо	Агаарын тухай хууль, Ус, Цаг Уур, Орчны Хяналт Шинжилгээний Тухай Хууль, Уур Амьсгалын

2	Цаг агаарын үзүүлэлт	Хяналтын 1 цэгт	Багажны худалдан авалт хийгдсэний дараа төлөвлөх		-	-	Багажгүй үеийн мэдээллийг ЦУОШГ-аас авах	Өөрчлөлтийн Үндэсний Хөтөлбөр, Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага, Агаарын чанарын хяналт хийх горим. ЭТТ-СА-ГО41-БО-ГО07-X02
3	Хийн төлөвт бохирдуулагч /NO ₂ , SO ₂ , H ₂ S, CO, Formaldehyde/	Уурхайн бүсийн хяналтын 13 цэг	Намар, өвөл	1 удаа	1.5	19.5	-	Агаарын тухай хууль, Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага, Агаарын чанарын хяналт хийх горим. ЭТТ-СА-ГО41-БО-ГО07-X08
4	Гадаад орчны дуу шуугианы хэмжилт	10 цэгт	14 хоногт 1 удаа	260 удаа	-	Өөрийн багажаар	-	Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага, Агаарын чанарын хяналт хийх горим. ЭТТ-СА-ГО41-БО-ГО07-X02
5	Тоосонцорын агууламжийн хүнд металлын шинжилгээ	Уурхай болон ажилчдын хотхоны 6 цэгт	Жилд	2 удаа	0.164	1.97		Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага, Агаарын чанарын хяналт хийх горим. ЭТТ-СА-ГО41-БО-ГО07-X02
6	Цацрагийн хяналт, шинжилгээ	Уурхайн хяналтын 10 цэгт	Жилд	1 удаа	-	Өөрийн багажаар		Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага, Агаарын чанарын хяналт хийх горим. ЭТТ-СА-ГО41-БО-ГО07-X02
Нийт						21.4		

12.2 Усны хяналт шинжилгээ

Тавантолгойн нүүрсний уурхайн бүс нутаг нь гадаргын усан сүлжээний хувьд Төв Азийн гадагшаа урсацгүй ай савд хамаарагдах бөгөөд Монгол орны ус зүйн мужлалтаар Галба-Өөш Долоодын усны сав газарт хамаарна.

Усны мониторингийн хөтөлбөрөөр үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаанаас газрын доорх усны горим, усны чанар, гидрогеохимийн найрлагад учруулж болзошгүй нөлөөлөл, өөрчлөлтийн хэмжээг тогтоохыг зорино. Газрын доорх усны мониторингоор уурхай ашиглалтын худгууд болон тусгай зөвшөөрлийн талбай дахь бага гүний худгуудын усны түвшиний өөрчлөлтийг тодорхойлох зорилготойгоор уст цэгүүдэд усны түвшин хэмжигч автологгер байршуулж жилийн турш тасралтгүй хяналт явуулна.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, сая. ₮	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Газрын доорх усны түвшин, ашиглалтын худгуудын усны түвшин	ГД цооног: GW713, 21, 11	Жил	6 цаг тутам	-	-	Solinst үйлдвэрийн гар түвшин хэмжигч багаж болон Levellogger автомат усны түвшин хэмжигч багаж ашиглан хэмжилтийг хийнэ.	Байгаль орчны хяналт шинжилгээний журам – ЭТТ-СА-Ж06-БО-Ж02-Х02
		Ашиглалтын худгууд: Уурхайн ашиглалтын худаг		14 хоногт 1 удаа	-	-		
2	Бага гүний усны түвшин	Малчны худаг /Гүн гашуу, Улаан овоо, Гурван толгой, Эргийн ус, Бунхант, Шорвогийн хүрэн толгой/		12 цаг тутам	-	-		
3	ГДУ геохимийн судалгаа: Макро, микро элемент	Уурхайн ашиглалтын болон ахуйн хэрэглээний худаг		Улиралд 1 удаа	0.330	19.5	-	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
		Нөлөөллийн бүсийн малчдын худаг /6 уст цэг/						
4	Ахуйн усны эрүүл ахуйн үзүүлэлт	Унд ахуйн усны эх үүсвэрүүд, ажилчдын хотхоны усны нөөцийн сав, цорго, усны машин /10 уст цэг/		Улиралд 1 удаа	0.100		-	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага,

		Нөлөөллийн бүсийн малчдын худаг /6 уст цэг/		Хагас жилд 1 удаа			-	чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага.
5	Саарал усны хяналт шинжилгээ	Цэвэрлэх байгууламжийн саарал ус /4 цэвэрлэх байгууламж/		Улиралд 1 удаа	0.794	3.177		
	Нийт					22.7		

12.3 Хөрс, ургамлан бүрхэвчийн мониторинг

Тавантолгой нүүрсний уурхай орчмын нутаг нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Говийн их мужийн хотгорын бүсшилийн Монголын өрнөд мужийн Даланзадгадын 33-р тойргийн зүүн хойт зах хэсгийн нутгийг хамаарна (Монгол Улсын Үндэсний Атлас, 2009). Нүүрсний уурхай орчмын газарт Цөлөрхөг хээрийн Сайр чулуурхаг бор хөрс, Цөлөрхөг хээрийн бор хөрс, Цөлөрхөг хээрийн мараалаг бор хөрс, Шал шалархуу хөрс, Сайрын хөрснүүд зонхилон тархана.

Уурхайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлж буй нөлөөллийг хянах зорилгоор хөрс бохирдох эрсдэл бүхий хяналтын цэгүүдээс дээж авч хөрсний хими физик, хүнд металлын үзүүлэлтүүдийг, удаан хугацаанд ашиглагдахгүй шимт хөрсний овоолгуудаас дээж авч хөрсний шим тэжээл, бохирдлын үзүүлэлтийг тус тус итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлнэ. Мөн уурхайн ажилчдын хотхоны цэвэрлэх байгууламжуудын орчмоос дээж авч хөрсний нянгийн үзүүлэлтүүдийг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлнэ.

2024 онд мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн Ургамлын мониторингийн хөндлөнгийн хэмжилтийн зөвлөмжийн дагуу 2025 онд ургамлын зүйлийн бүрдлийг тодорхойлохуйц мониторингийн цэгүүдийг нэмэгдүүлж 6 трансектийн дагуу 26 цэгт ургамлын мониторингийг хийж гүйцэтгэхээр төвлөсөн.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, сая.₮	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Хөрсний чанар-Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	Хяналтын 10 цэг	Жил	2 удаа	Гүйцэтгэлээр	12.8	-	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний

2	Хөрсний чанар- нянгийн шинжилгээ	ЭТТ ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын цэвэрлэх байгууламжийн орчим		2 удаа			>5	дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990
3	Хөрсний чанар- Хүнд металл, нефтийн бүтээгдэхүүний шинжилгээ	ШТС болон хаягдал тосны талбай, бохирдсон хөрс саарамагжуулах талбайн орчим		2 удаа			>5	
4	Шимт хөрсний овоолгын үржил шим, хөрсний хими, физикийн шинжилгээ	Цанхийн баруун, зүүн уурхайд удаан хугацаанд хадгалсан шимт хөрсний овоолгууд		2 удаа			>10	
5	Тусгай зөвшөөрлийн талбайнд ургамлын мониторинг хийх	6 трансектийн дагуу 26 цэгт		2 удаа	-		Нөлөөллийн бүсэд ургадаг бэлчээрийн ургамлын геоботоникийн бичиглэл хийх	Байгалийн ургамлын тухай Монгол улсын хууль, ЭТТ ХК-ийн дотоод журмууд Өнгөн хөрстэй ажиллах журам, Ховор, нэн ховор ургамлыг хамгаалах журмууд
	Нийт				12.8			

13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, сая ₮	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцах ажилтан
			1-улирал	2-улирал	3-улирал	4-р улирал	
1	ЭТТ ХК-ийн Байгаль орчны инженерүүд болон гэрээт компанийн Байгаль орчны мэргэжилтнүүдэд сургалт, зааварчилгаа хүргэх	-	ISO14001:2015 стандартын мэдлэг ойлголт нэмэгдүүлэх	DustTrak төхөөрөмж ашиглах чадварыг сайжруулах	Байгаль орчны хууль, эрхзүйн сургалт		ЭТТ ХК
2	Гэрээт компаниудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг зохион байгуулах.		БОМТ-г батлах, гэрээний хэрэгжилтийг хангуулах	Хог хаягдлын байгууламжуудын стандарт шаардлагыг нийцүүлэх	Зөрчил, үл нийцлийг арилгуулах	БОМТ-н хэрэгжилтийг хангуулах	ЭТТ ХК
3	Гэрээт компаниудын гэрээний хэрэгжилтийг сар бүр KPI оноогоор үнэлэж гэрээ дүгнэлтийн Тайлан төлөвлөгөөний стандартыг хангуулах.	-	Тогтмол				ЭТТ ХК
4	Тавантолгой- Гашуун сухайт чиглэлийн тээврийн зам дагуу нөлөөллийг бууруулах ажлыг зохион байгуулах.		-	-	Зогсоолын талбайг нэмэгдүүлэх	Нийтийн бие засах газрын тоог нэмэгдүүлэх	ЭТТ ХК
5	Цагаан-Овоо багийн малчдын хоршооллыг дэмжих	19.0	2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Билэгт малчид хоршоололтой байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд				ЭТТ ХК
6	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах	19.0	Дэлхийн усны өдөр, ойн өдөр	-	-	Байгаль хамгаалах өдөр	ЭТТ ХК

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, сая ₮	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцах ажилтан
			1-улирал	2-улирал	3-улирал	4-р улирал	
8	Галба-Өөш долоодын говийн сав газрын захиргааны зөвлөлийн хурлыг зохион байгуулах	18.0	+				ЭТТ ХК
9	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Баян-Овоо, Номгон, Манлай, Цогт-Овоо сумдад “Заг” төсөл хэрэгжүүлэх. />50 га/	Үйл ажиллагааны төсөв	+	+	+	+	ЭТТ, ХХЕГ ЭТТ
10	Тэрбум үндэсний хөтөлбөрийн хүрээнд Цогтцэций суманд “Ногоон зам” төслийн дагуу хамгаалалтын ойн зурвас байгуулах. />10 га/		+	+	+	+	
11	Орвог гашууны тооройг ойн аж ахуйн арга хэмжээг авч хэрэгжүүлэх. />5 га/		+	+	+	+	ЭТТ, ХХЕГ
	Нийт	56.0					

14 НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Цогтцэций сумын Цагаан-Овоо, Билгэх, Сийрст багийн иргэдэд БОМТ-нд тусгагдсан малчид болон олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээний төлөвлөгөө, удирдамжуудыг тухай бүр танилцуулж, хэрэгжсэний дараа ажлын тайлан, мэдээг цаг хугацаанд нь тайлагнаж ажиллана.

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Нийт зардал, сая ₮	Хариуцах ажилтан	Зохион байгуулах газар
1	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгууллагын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулах	Компанийн албан ёсны вэб хуудас	Байгаль орчны хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн үр дүн.	II улиралд	-	ЭТТ	Цогтцэций сум
2	Цогтцэций сумын Цагаан-Овоо, Билгэх, Сийрст багийн иргэдэд танилцуулах	Олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	БОМТ болон БОМТ-ний биелэлтийг танилцуулах.	Жилд 2 удаа	19.8		
Нийт					19.8		

15 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ

Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв.

№	БОМТ ангилал	Төсөв, мян.төг
1	Сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээ	205.3
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	139.2
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	350.0
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	53.7
6	Осол эрсдэлийн менежмент	104.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	327.3
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	56.97
9	Удирдлага зохион байгуулалт	56.0
10	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	19.8
Нийт		1.312.97